

БНХАУ-ЫН ЦӨӨНХ ҮНДЭСТЭН ОРШИН СУУДАГ БҮС НУТАГ ДАХЬ ХӨДӨӨГИЙН САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО

М.Бүрэнжаргал*

Товч агуулга. Хятад улсын цөөн тоот үндэстний газар тариалан, мал аж ахуйн бүс нутгийн ихэнх нь байгалийн гамшигт өртөмтгий, хүрээлэн буй орчин нилээд доройтсон, эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур бүс нутагт хамаардаг. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд тус бүс нь бусад мужуудаас хөгжлөөр хоцрогдсон төдийгүй бүс доторх хөгжил нь ч харилцан адилгүй юм. Санхүү нь эдийн засагтаа тулгуурлаж байдаг боловч эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү өгүүлэлд цөөн тоот үндэстний бүс нутгийн хөдөөгийн санхүүгийн тогтолцоо нь бүрэлдэн тогтохдоо хөдөөгийн санхүүгийн тогтвортой хөгжилд тулгуурлах ёстой, мөн зах зээлийн болон захиргааны арга хэрэгслийг оновчтой хослуулах замаар санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах, бодлогын зохицуулалт бүхий санхүүг чиг удирдлага болгож, хамтын ажиллагааны санхүүг гол болгон, арилжааны санхүүг дэмжлэг болгосон олон шатлал бүхий хөдөөгийн санхүүгийн тогтолцоог тогтвортой хөгжүүлэх талаар тусгалаа.

Түлхүүр үгс: БНХАУ-ын цөөн тоот үндэстний бүс нутаг, хөдөөгийн санхүүгийн тогтолцоо, тогтвортой хөгжил

Бодит туршлагаар БНХАУ-ын цөөн тоот үндэстний бүс нутгийн хөдөө тосгоны эдийн засгийн хөгжилд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Аажмаар зах зээлд шилжих явцад энэ талын хөрөнгө оруулалт санхүүгийн үйлчилгээний тал дээр илүү тод илэрч байна. Цөөн тоот үндэстний бүс нутгийн хөдөө аж ахуйн хөгжил гэдэг нь зөвхөн үе дамжсан эдийн засгийн чинээлэг амьдрал, зарим бүс нутгийн эдийн засгийн хөгжил биш, харин санхүүгийн зах зээл дээр тулгуурласан байнгын эдийн засгийн хөгжил юм. Санхүүгийн систем нь санхүүгийн үйлчилгээг тэтгэн тасралтгүй хөгжих хөдөө орон нутгийн санхүүгийн эх үүсвэр болж, цөөн тоот үндэстний бүс нутгийн газар тариалан, хөдөө орон нутаг, иргэдийн тасралтгүй хөгжих явцад илүү сайн үйлчлэх ёстой. Тиймээс хөдөө орон нутгийн санхүүгийн цогц системийг бүрдүүлэх нь санхүүгийн тасралтгүй хөгжилд тулгуурласан байна.

Нэг. Бодлогын зохицуулалт бүхий санхүүг чиг удирдлага болгох

Ерөнхийдөө, хөдөө аж ахуй нь байгалийн хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн эрэлт хэрэгцээнээс хамааран тогтдог байна. Хөдөө аж ахуйн салбарт зах зээлийн систем тодорхой хэмжээнд үйлчилдэггүй учраас засгийн газар идэвхтэй оролцох төдийгүй хөдөө орон нутгийн зээлийн бодлого болон даатгалын тал

* М.Бүрэнжаргал- Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын сургуулийн багш, доктор (Ph.D)

дээр бодлогын чанартай санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг. Хөдөө аж ахуйн онцлогоос харахад засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн дэмжлэгийн нийгэмд үзүүлэх нөлөө нь илүү, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах нь зөвхөн хөдөө эрон нутгийн орлогод нөлөөлөөд зогсохгүй бусад салбарт ч гэсэн сайн сайхан байдлыг бий болгодог. Өөрөөр хэлбэл орлого хувиарлалт болон эдийн засгийн тогтвортой байдлыг нь голдуу засгийн газар зохицуулж байна. БНХАУ нь бодит байдал дээр 800 сая тариачин хүн амтай, мөн хөдөө аж ахуй нь улсын эдийн засгийн суурь болдог учраас төв засгийн газар нь цөөн үндэстний бүс нутгийн хөдөө аж ахуйн эдийн засагт бодлогын чанартай санхүүгийн хөрөнгө оруулалт хийх үүрэг хариуцлага хүлээдэг. Хөрөнгийг үр ашигтай хуваарилах эдийн засгийн үүргээс шалтгаалж засгийн газар нь шат бүрдээ бодлогын чанартай санхүүгийн дэмжлэг үзүүлэх ёстой. Зарим судлаачдын үзэж байгаагаар, хөдөө орон нутгийн бодлогын чанартай санхүүгийн байгууллага (Жишээ нь Хөдөө орон нутгийн хөгжлийн банк) нь бодлогын зохицуулалтын шинжтэй үйл ажиллагаанаас худалдааны чиглэлтэй үйл ажиллагаа руу шилжиж байна. Хэдийгээр БНХАУ-ын цөөн тоот үндэстний бүс нутгийн хөдөө аж ахуйн бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн систем нь тодорхой төвшинд хөгжиж байгаа ч бас дутагдалтай тал олон байна. Олон улсын туршлагаас харахад, улсын бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн систем нь байнга өөрчлөгдөж, аливаа бүс нутаг сул дорой нөхцөл байдлаасаа ангижирч, өөрсдөө хөрөнгө оруулалт хийх чадвартай болсон нөхцөлд тухайн зах зээл дээр хэрэгжиж байгаа бодлогын чанартай санхүүгийн системийг зогсоож болдог байна. Гэвч БНХАУ нь хөгжиж байгаа орон, цөөнх үндэстэн төвлөрсөн хөдөө орон нутаг нь харьцангуй хоцрогдмол, арилжааны банк ажиллахгүй, хувийн санхүүгийн систем өсч хөгжих нөхцөл боломжгүй учраас бодит нөхцөл байдлаас шалтгаалан, бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн систем нь илүү хүчирхэгжих боломжтой байна.

Ерөнхийдөө, олон үндэстэн ястан төвлөрсөн хөдөө орон нутгийн дэд бүтэц муу, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төвшин доогуур, зохион байгуулан удирдах чадвар сул, мэдээлэл жигд бус, зах зээлийн систем нь боловсронгуй биш байдаг учраас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн болон зах зээлийн эрсдэл нилээд өндөр байдаг. Санхүү нь эдийн засагтаа тулгуурладаг, бодит эдийн засгийн хөгжил сул учраас цөөнх үндэстэний бүс нутаг дахь албан ёсны санхүүгийн үйлчилгээ хүрэлцээгүй, санхүүгийн нөөц их хэмжээгээр гадагш урсдаг байна. Түүний дотор дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ их, урт хугацаатай байдаг, мөн хөдөө аж ахуйн бодит нөхцөл байдал болон үндэстэн ястан төвлөрсөн бүс нутгийн бодит байдалтай уялдаатайгаар тухайн бүс нутгийн үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил нь эрсдэл өндөртэй хэдий ч үндсэндээ санхүүгийн үйлчилгээ тэгш, хүрэлцээтэй байх шаардлагатай учраас засгийн газар нь тодорхой хэмжээний бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн дэмжлэг үзүүлж, цөөнх үндэстэн төвлөрсөн бүс нутгийн санхүүгийн үйлчилгээг сайжруулан хөгжүүлэх нь зах

зээлийн горимд нийцэж байдаг.

Цөөнх үндэстний бүс нутгийн хөдөөгийн бодлогын зохицуулалт бүхий санхүү нь засгийн газраас үүсгэн зохион байгуулж, улсын зээлд тулгуурлаж, хөдөө аж ахуйн бодлого болон хөдөөгийн үйлдвэрлэлийн бодлогыг бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хослуулан хэрэгжүүлэх чухал үүрэг бүхий, хөдөө аж ахуй болон бусад холбогдох салбаруудад нөөцийг эргэлтэнд оруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин хөдөө аж ахуйг болон эдийн засгийн хөгжлийг урамшуулж, тариачдын орлогыг өсгөхүйц ашгийн төлөө бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх санхүүгийн хэлбэр юм. Хөдөө аж ахуйн бодлогын чанартай даатгал нь мөн хөдөө орон нутгийн санхүүгийн системийн гол бүрдүүлэгч хэсэг төдийгүй нэг талаар хөдөө орон нутгийн санхүүгийн эрсдлийг багасгахын зэрэгцээ санхүүгийн байгууллага санхүүгийн зах зээлд оролцож, идэвхитэй нөлөө үзүүлэхэд түлхэгч хүчин болно.

Хоёр. Хамтын ажиллагааны санхүүг төв болгох

Шударга, үр ашигтай нийгмийн хөгжлийн явцад зөвхөн бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн систем байснаар тухайн бүс нутгийн бүх санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үүргийг биелүүлж чадахгүй. Харин хамтын ажиллагааны болон өрсөлдөөний шинж чанартай санхүүгийн систем нэвтрүүлэх нь олон улсын жишигт, мөн БНХАУ-ын бодит нөхцөл байдалтай нийцүүлэн хэрэгжүүлэхэд үр ашигтай зөв шийдэл байж болох юм. Цөөнх үндэстний бүс нутгийн нийгэм нь эдийн засгийн янз бүрийн хэлбэр бүтэцтэй ба малчин тариачдын орлогын төвшин харьцангуй бага, барьцаанд тавих зүйл дутмаг, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь мөчлөгийн болон улирлын шинж чанартай, арилжааны чанартай санхүүгийн үйл ажиллагаа нь тухайн бүс нутагт бүрэн утгаараа хөгжиж чадаагүй байдаг. Ашгийг чухалчилсан арилжааны банк хөдөө орон нутгаас гарч явах нь зах зээлийн эдийн засгийн бодит нөхцөл байдалтай уялдаа холбоотой. Хэрэв бүс нутгийн эдийн засгийн олон талт байдал, санхүүгийн хэрэгцээний жигд бус, мэдрэмтгий онцлог бүхий эдийн засгийн хэлбэрийг тооцолгүйгээр цөөнх үндэстний бүс нутаг дахь хөдөөгийн санхүүгийн байгууллагыг арилжааны болгох замаар санхүүгийн хэрэгцээг хангахыг оролдох нь тухайн бүс нутгийн санхүүгийн хэрэгцээг хангаж чадахгүйгээр үл барам арилжааны санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа амжилтгүй болоход хүргэнэ. “Гурван хөдөө” стратегийн зорилгыг хэрэгжүүлэхээр зорьсон сүүлийн жилүүдэд цөөнх үндэстний хөдөөгийн бүс нутагт санхүүгийн хөрөнгийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал өнөөг хүртэл тод илэрсээр байна. Бид заавал цөөнх үндэстний бүс нутгийн санхүүгийн систем тогтвортой хөгжих шаардлагад нийцсэн шинэ санхүүгийн хэв маягийг бий болгож, арилжааны чанартай санхүүгийн эрэлт хэрэгцээнээс ангид салган үзэх ёстой ба ингэснээр хөдөө орон нутгийн хамтын ажиллагааны санхүүгийн системийг бүрдүүлэх болно.

Хамтын ажиллагааны санхүүгийн системийн хувьд түүний хамтран ажиллах, мөн нийгмийн эмзэг давхаргын хүмүүсийг дэмждэг онцлог шинж нь

цөөнх үндэстний бүс нутгийн санхүүгийн системд голлох байр эзлэх үндэс нь болдог. Хамтын ажиллагааны санхүүгийн системийг өөрийнх нь агуулга, зарчимд тулгуурлаж, онцлог шинжийг нь шинжилбэл эн тэргүүнд, харилцан хамтран ажиллах эдийн засгийн зохион байгуулалтын хэлбэртэй, Байгууллагууд харилцан туслалцах хэлбэрээр гишүүдийн хөрөнгийн илүүдэлтэй үе болон эрэлт хэрэгцээний зөрүүтэй байдлыг ашиглан зохицуулалт хийдэг. Хоёрдугаарт, таатай нөхцөл бололцоо дутмаг хэсэгт үйлчлэх үүрэгтэй. Харилцан туслалцах аргыг хэрэглэн ядуу өрхүүд, эмзэг давхаргын хүмүүсийн санхүүгийн дутмаг асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Эцэст нь хэлэхэд энэ нь арилжааны санхүүгийн бүтээгдэхүүнээс ялгаатай. Хадгаламж зээлийн хоршооны субъект нь зөвхөн гишүүнчлэлийн зарчимтай, харьцангуй хаагдмал байдалтай байдаг. Мөн хадгаламж зээлийн хоршооны үйлчилгээний гол зорилго нь санхүүгийн эрэлт хэрэгцээтэй гишүүнд хөрөнгө нийлүүлэх үйлчилгээ үзүүлж, үйлдвэрлэлийн явцад үүссэн хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлыг арилгаж, гишүүд хоорондоо харилцан туслалцаж өрсөлдөөний шинж чанар агуулахгүй зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх явдал байдаг.

Хамтын ажиллагааны санхүүгийн систем нь 150 гаруй жилийн түүхтэй бөгөөд өнөө үед дэлхийн бүх улс орны санхүүгийн системийн чухал хэсэг болжээ. Франц, Герман, Япон зэрэг улсын хөдөө орон нутгийн санхүүгийн систем нь одоо ч хамтын ажиллагааны санхүүгийн системийг голлодог, мөн Америкийн хөдөө орон нутгийн хамтын ажиллагааны санхүүжилтийн систем нь засгийн газрын дэмжлэгтэйгээр хөдөө орон нутгийн санхүү болон эдийн засгийн хөгжлийг түлхэх гол тулгуур хүч болсон байна. Бодит байдал дээр БНХАУ-ын түүхэнд хамтын ажиллагааны санхүүгийн систем байгаагүй. 80 гаруй жилийн турш унаж босч байсан хятадын “хамтын ажиллагааны санхүү”-гийн хөгжил 1923 онд Хэбэй мужийн Сянхө тосгоны хадгаламж зээлийн хоршооноос эхэлсэн юм. 1980-аад оноос эхэлсэн өөрчлөлтийн үр дүнгээс харахад БНХАУ-ын “Хамтын ажиллагааны санхүүгийн байгууллага” нь хамтын ажиллагааны санхүүгийн системийн шинжээс холдож, хөдөө орон нутгийн хадгаламж зээлийн хоршоо нь төрийн банкны хөдөө орон нутаг дахь үндсэн байгууллага болж, хамтын ажиллагаа нь төрийн институц болон хувирснаар хүмүүст гүн гүнзгий буруу ойлголт төрүүлсэн. Өөрөөр хэлбэл одоогийн хөдөө орон нутгийн санхүүгийн системийн гол цөм болсон орон нутгийн хадгаламж зээлийн хоршоо нь хамтын ажиллагааны санхүүгийн шинжтэй бус, харин хамтын ажиллагааны гэдэг нэрээ ашиглан арилжааны чанартай санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байна. БНХАУ-ын хөдөө орон нутгийн хадгаламж зээлийн хоршоо болон хамтын ажиллагааны санхүүгийн системийн эдийн засгийн үндсэн шинж чанар нь харилцан адилгүй, өнөөгийн байдлаар өөрчлөгдөх явц дундаа байгаа бөгөөд хамтын ажиллагааны санхүүгийн систем рүү өөрчлөгдөн шилжих зорилт тавьж байгаа ч хэрэгжүүлэх явцад төрөл бүрийн хүндрэл үүсч байна. 1-рт, хамтран ажиллах, харилцан туслах болон санхүүгийн чадвар муу хүмүүст туслах үйлчилгээний үүрэг үндсэндээ алдагдаж,

үйлчилгээний шинж чанар, онцлог, объект болон удирдлагын арга хэлбэр нь бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн системтэй холилдож, БНХАУ-ын санхүүгийн систем дунд “юу ч биш” гажиг зүйл болж хөгжсөн. 2-рт, гишүүд нь чөлөөтэйгөөр байгууллагаас гарах эрхгүй, гишүүд болон хадгаламж зээлийн хоршоо хоорондох эд хөрөнгийн эрхийн харилцаа нь тодорхой бус, хамтран хуримтлуулсан хуримтлалаа хуваарилах систем нь бүр ч тодорхой бус, хуулийн этгээдийн өмчлөх эрх ойлгомжгүй. 3-рт, ашгаас хүртэх эрх нь тодорхойгүй учраас ашиг хүртэх гол эрх бүхий этгээдийн байр суурь үгүй болж, ашиг хүртэх ёстой гишүүн нь ашгаас хүртэхгүй байдал үүссэн. 4-рт, ардчилсан удирдлагын “гурвалсан хамтын ажиллагаа” нь нэр төдий болж, дотоодоос захирах үзэгдэл тод илрэн бодит байдал дээр төлөвлөгөөт үйлдвэрлэл болон захиран тушаах өнгө аясаар удирдах болсон байна.

Гурав. Арилжааны санхүүг дэмжлэг болгох

Одоогийн байдлаар цөөнх үндэстний хөдөөгийн дийлэнх бүс нутагт хоцрогдмол, ядуу байдал оршсон хэвээр байгаа бөгөөд бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн системийг дэмжих хандлагыг барьж, хамтын ажиллагааны санхүүгийн системийг голчлон сонгох нь бодит нөхцөл байдалд нийцэх сонголт болж байна. Гэвч ердийн “ядуу” гэсэн ойлголтоос болж баян хэсгийг үл ойшоох, дийлэнх “хоцрогдмол” хэсгээс болж хөгжсөн газрыг үл ойшоож болохгүй. Энэ нь бид бүгдийн баримталж байгаа зарчимтай нийцэхгүй. Бодит амьдрал дээр БНХАУ-ын бусад бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн явцад “2 секторт бүтэц” оршин байгаатай адил, баруун хэсгийн цөөнх үндэстэн төвлөрсөн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд мөн 2 секторт эдийн засгийн шинж чанар, мөн бүс нутгийн дотоодын тэнцвэргүй хөгжил нийтлэг оршин байна. Арилжааны шинж санхүүгийн зах зээлийн хөгжил нь зах зээлийн эдийн засгийн үзэгдэл бөгөөд тогтвортой хөгжиж буй цөөнх үндэстний бүс нутгийн санхүүгийн систем бүрэлдэхэд туслах үүрэг гүйцэтгэнэ. Учир нь: 1-рт, хөдөө орон нутгийн санхүүгийн систем зах зээлийн горимд шилжих нь хөгжлийн зайлшгүй хандлага юм. Хэрэв зөвхөн бага хүүтэй, хүүгийн дэмжлэгт түшиглэж зах зээлийн горимын эсрэг ажилласан нөхцөлд үр ашиг бага байдаг. Бага хүүтэй зээл нь нэг төрлийн сайн сайхан зүйл мөн, нийгмийн тогтолцоо дунд эцэстээ эрх мэдэлтэй, нөлөөтэй хүмүүсийн гарт төвлөрөх магадлал өндөр байдаг учраас ирээдүйд хүссэн үйлчилгээндээ хүрч чадахгүй байдалд хүрдэг. Зөвхөн хөдөө орон нутгийн санхүүгийн эрсдлийг зах зээлийн тусламжтайгаар зайлуулснаар санхүүгийн үйл ажиллагаа тогтвортой хөгжих боломжтой. 2-рт, бүс нутаг дотор эдийн засгийн хөгжил тэгш бус, төрийн өмчит банк арилжааны шинж чанар руу шилжих бодит сонголтыг хийдэг учраас төрийн өмчийн арилжааны банк нь орон зайны хувьд жигд бус тархсан байдалд зохицуулалт хийдэг. Төрийн өмчит арилжааны банкны салбар байгууллага нь ажлын ачаалал бага, хөрөнгийн итгэлцлийн түвшин тодорхой бус, ашиг олох боломж багатай хөдөө орон нутаг болон зах хязгаарын бүс нутаг зэрэг санхүүгийн хувьд хоцрогдмол зах зээлээс

үйл ажиллагааны сүлжээгээ татан авч, үйлчилгээний зорилтоо зах зээл өндөр хөгжсөн бүс нутагт шилжүүлэх нь арилжааны санхүүгийн үйл ажиллагаанд заавал баримтлах ёстой зарчим. Мөн хөдөө орон нутгийн хадгаламж зээлийн хоршоо, хувийн хэвшлийн санхүүжилт, цөөнх үндэстний бүс нутгийн жижиг хэмжээний арилжааны чанартай санхүүгийн байгууллагын чөлөөлсөн орон зайд төрийн өмчит арилжааны банк нь зохистойгоор тархан байршиж, цөөнх үндэстний бүс нутгийн санхүүгийн үйлчилгээ тогтвортой хөгжих, анги давхарга бүр хөгжих ашигтай нөхцөл бүрдүүлж өгдөг. 3-рт, цөөнх үндэстний бүс нутгийн эдийн засгийн хөдөө тосгон, тариачин, хөдөө аж ахуйг зах зээлийн хувьд нарийн ангилж, түвшингээр нь заагласнаар бүс нутгийн санхүүгийн үйлчилгээг олон талтай болгож, бодлогын зохицуулалт бүхий санхүүгийн болон хамтын ажиллагааны санхүүжилтийн дангаар ноёрхсон байдал, дутагдалтай талыг нөхөж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэн үр ашгийг дээшлүүлж, бүс нутгийн эдийн засгийн худалдаа хөгжих, үйлдвэржих, стандарчлах, хотжих явцыг түргэсгэнэ.

Цөөнх үндэстний бүс нутгийн арилжааны шинж чанартай санхүүгийн систем нь бүс нутгийн эдийн засгийн илүү өндөр төвшний үйлчилгээг хөгжүүлэх арилжааны санхүүгийн систем, хувийн хэвшлийн санхүүгийн байгууллага болон тэдгээрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжихийн тулд арилжааны банкны гурван талт зарчмыг үндэслэж үйл ажиллагаагаа удирдаж, зээлийн эрсдлээр хүүгийн төвшинг тогтоодог. Голдуу зах зээлд тулгуурлаж, олон үндэстний бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, худалдаа, цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах, хувийн үйлдвэрлэлийг үндэслэн бүтээн байгуулах зэрэг харьцангуй өндөр төвшний санхүүгийн хэрэглэгч болон “эмзэг давхаргын бүс” хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Жишээ нь цөөнх үндэстний бүс нутаг нь аялал жуулчлалын салбарын нөөц баялаг ихтэй төдийгүй зах зээлийн хөгжлийн ирээдүй сайн, мөн хилийн худалдаа, эдийн засаг ч гэсэн сайн хөгжих хандлагатай. Түүн дотор, хөрөнгийн эх үүсвэр дутагдах нь хөгжилд саад болох гол хүчин зүйл болдог. Хөдөө орон нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг, хувиараа бизнес эрхлэгчид, айл өрх нь арилжааны хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн зээлийн хэрэгцээтэй байдаг нь хөрөнгийн хангагдаагүй хэрэгцээ нь хөдөө орон нутгийн арилжааны хөрөнгө орж ирэх, мөн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлдэг.

Өнөөг хүртэл БНХАУ-ын дотоодод зарим бодлогын чанартай үндсэн тогтолцоо дутагдалтай байгаа нь арилжааны чанартай санхүүгийн систем цөөнх үндэстэн ястан төвлөрөн суусан бүс нутагт үр ашигтай хөгжих явдлыг хязгаарлаж байна. 1-рт, малчин тариачид нь арилжааны зээлийн барьцаа хөрөнгө байхгүй, тэдэнд орон сууц болон газар өмчлэн эзэмших эрх байдаггүй шалтгаанаар зээл авахад хүндрэл учирч байна. 2-рт, БНХАУ-д хөдөөгийн иргэдэд зээлийн баталгаа олгож буй компанид засгийн газраас дэмжлэг үзүүлж байгаагүй, санхүүгийн хөрөнгө хэрэгцээтэй хүмүүс нь тохиромжтой хууль ёсны батлан даагч байхгүй байдгаас шалтгаалан арилжааны санхүүгийн байгууллага нь зээл өгөхөөс татгалзах нөхцөл байдал үүсдэг. 3-рт, хөдөө орон нутагт зээлийн

систем бүрдээгүй, зээлдэгчийн эдийн засгийн үйл ажиллагаа тогтворгүй, мөн зээлийн хэмжээ бага, тархаан хуваарилсан байдлаас шалтгаалж хөдөөгийн арилжааны сээлийн үйл ажиллагааны өртөг өндөр байдаг. Үүнээс гадна цөөнх үндэстэн суурьшсан бүс нутагт арилжааны чанартай хөдөө аж ахуйн даатгалын байгууллагын салбар нэгж байдаггүй учраас орон нутгийн эдийн засаг болон арилжааны санхүүгийн систем нь санхүүгийн батлан даагч байгууллага болон тухайн тогтолцоогоор дутагдаж байдаг. Мэдээж цаашид хөдөө орон нутгийн эдийн засгийн системийн өөрчлөлт болон санхүүгийн систем бүрэлдэхэд бид эдгээр асуудлуудыг боловсронгуй болгох ёстой.

Ном зүй:

1. Се Лисян /谢丽霜/: 《 Баруун бүс нутгийн бүтээн байгуулалтын явц дахь санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн хөгжил 》 (М), Далянь, Зүүн хойдын Санхүүгийн дээд сургуулийн хэвлэлийн газар, 2003. : 《西部开发中的金融支持与金融发展》 (М), 大连, 东北财经大学出版社, 2003.

2. Чэнь Шисин /陈时兴/, Ца Зумин /蔡祖明/ : 《 БНХАУ-ын хөдөө орон нутгийн санхүүгийн үйлчилгээний системийг боловсронгуй болгох талаарх ерөнхий ойлголт 》 (L), 《 Бичиг баримтын мэдээлэл 》, 2006N0. 3, P:18-20. : 《关于完善我国农村金融服务体系的观点综述》 (L), 载《资料通讯》, 2006N0. 3, P:18-20.

3. Дун Юйхуа /董玉华/ : 《 Зах зээл, засгийн газар болон газар тариалан, тариачин, газар тариалангийн санхүүжилт 》 (L), 《 Хөдөө орон нутгийн санхүүгийн системийн судалгаа 》, 2007N0.6, P:9-16. : 《市场、政府与农业、农民、农村金融》 (L), 载《农村金融研究》, 2007N0.6, P:9-16.

Орчуулсан Б. Нарантунгалаг